



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 26 өдөр

Дугаар A/42

Хажуу шинэ-Ус

Г  
Орон тооны бус байнгын комисс  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 269 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Салбар хорооны дарга: Б.Даваасүрэн (Засаг даргын орлогч)

Нарийн бичиг дарга: Э.Сувдмаа (Хөдөлмөр эрхлэлт халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Гишүүдэд: Н.Долгорсүрэн (Эрүүл мэндийн төвийн дарга)

П.Отгонжаргал (Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч)

Т.Уранчимэг (Ерөнхий боловсролын сургуулийн захирал)

Ванчиндорж (Хэсгийн төлөөлөгч)

Т.Цэрэнчунт (Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн)

Г.Булган (Нийгмийн даатгалын улсын байцаагч)

А.Бямбадорж (Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч)

2. Сумын албан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд комисс байгуулан засгийн газраас баталсан үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрмийн 3 дугаар зүйлийн 3.2 дах заалтыг хэрэгжүүлэн ажиллахыг орон тооны бус байнгын комисст үүрэг болгосугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан 2018 оны 05 дугаар сарын 04-ны өдрийн A/37 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ДАРГА  Т.АРИУНАА

482401042